



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 09 өдөр

Дугаар A/352

Улаанбаатар хот

**Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан
тогтоох орон тооны бус байнгын комиссыг
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан тогтоох орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүнийг шинэчилж, хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгож, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод судалгаа дүгнэлт гарган ажиллахыг Орон тооны бус байнгын комисс (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны A/378 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011056